



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2023/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
4. Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. Аудитын илрүүлэлт.....	13
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын санал дүгнэлт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сууц
Дундговь аймг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ч.УРАНЧИМЭГ ТАНАА

2023.03.25

№ 134

таныг _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-г заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд боловсрол, соёл, эрүүл мэндийн салбаруудын төсөвт байгууллагууд төсвийн шинэчлэлтэй холбоотой орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжин, орон нутгийн хөрөнгөнөөс 1,644,763.5 мянган төгрөгийн хөрөнгийг БСШУЯ, 952,273.1 мянган төгрөгийн хөрөнгийг ЭМЯ, 119,526.4 мянган төгрөгийн хөрөнгийг Соёлын яамд шилжүүлсэн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг даргаас хүргүүлсэн чиглэлийн дагуу үндсэн чиг үүрэгт хамааралгүй, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан 20,000.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

3012020267

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 117 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 82.6 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,434,089.9	853,360.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	403,205.6	468,191.8
33	АВЛАГА	472,159.0	225,007.2
35	БАРАА МАТЕРИАЛ	558,725.4	160,161.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,758,303.8	1,477,437.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,758,303.8	1,477,437.6
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	3,685,749.8	1,462,179.6
39300	Биет бус хөрөнгө	72,554.0	15,258.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,192,393.8	2,330,798.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,193.5	5,150.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,193.5	5,150.0
41300	Өглөг	21,193.5	5,150.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,171,200.3	2,325,648.2
51	Засгийн газрын хувь оролцоо	5,171,200.3	2,325,648.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,874,399.9	608,503.9
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,874,399.9	608,503.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,756,167.5	1,298,210.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,540,632.9	418,933.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,192,393.8	2,330,798.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,824,324.6	1,226,772.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	274,263.7	240,263.9
110	Орлогын албан татвар	31,099.5	145,020.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	31,099.5	145,020.0
113	Хөрөнгийн албан татвар	36,803.0	73,970.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	206,361.2	21,273.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,169,344.7	234,573.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,169,344.7	234,573.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,380,716.3	751,935.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,911,500.1	1,120,726.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,911,500.1	1,120,726.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,050,964.0	816,752.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,341,919.3	228,443.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,934.6	27,833.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,496.4	18,849.6
2104	Хангамж, бараа материалын зардал	121,796.2	144,331.5
2105	Нормативт зардал	434,417.6	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,989.8	63,985.8
2107	Томилолт, зочны зардал	3,816.0	7,691.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,269.5	30,853.8

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	715,324.5	294,762.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	860,536.1	303,974.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	912,824.6	106,046.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	51,456.9	2,722,833.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	861,367.6	-2,616,786.1

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,296,332.60	4,296,332.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,500.00	13,500.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,309,832.60	4,309,832.60
9	Тайлант үеийн үр дүн	861,367.60	861,367.60
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,171,200.30	5,171,200.30
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,171,200.30	5,171,200.30
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-348,292.50	-348,292.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,822,907.80	4,822,907.80
19	Тайлант үеийн үр дүн	-2,616,786.10	-2,616,786.10
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,325,648.20	2,325,648.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,636,604.6	1,186,528.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	274,263.7	240,263.9
110	Орлогын албан татвар	31,099.5	145,020.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	31,099.5	145,020.0
113	Хөрөнгийн албан татвар	36,803.0	73,970.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	206,361.2	21,273.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,958.9	13,584.4
1181	Газрын төлбөр	2,285.5	7,689.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	191,116.8	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	199,712.4	200,534.1
120	Нийтлэг татварын бус орлого	199,712.4	200,534.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,162,628.6	745,730.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,156,896.0	872,263.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,156,896.0	872,263.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,290,998.4	794,605.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,347,877.4	281,900.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	173,843.6	32,428.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,757.4	186,484.4
2104	Хангамж, бараа материалын зардал	89,208.8	38,998.1
2105	Нормативт зардал	248,354.3	0.0
2106	Эд хогшил, урегал засварын зардал	35,358.7	65,495.8
2107	Томилолт, зочны зардал	3,816.0	7,691.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,276.7	30,853.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,505.6	150,753.8

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	865,897.6	77,657.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	479,708.6	314,265.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	98,432.2	177,279.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	98,432.2	177,279.0
2200	Дотоод эх үүсвэрээр	98,432.2	177,279.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-98,432.2	-177,279.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-82,000.0	-72,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	82,000.0	72,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	299,276.4	64,986.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	103,929.1	403,205.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	403,205.6	468,191.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,426,226.7	1,023,388.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	954,452.0	777,859.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	932,616.2	757,088.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	306,136.2	281,900.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,634.0	32,428.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,948.0	186,484.4
2104	Хангамж, бараа материалын зардал	39,505.8	36,645.5
2105	Нормативт зардал	90.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,879.2	67,295.2
2107	Томилолт, зочны зардал	9,334.5	7,691.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,081.3	12,389.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,007.2	132,253.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,835.8	20,771.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,835.8	20,771.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	373,447.7	173,529.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,327.0	72,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,426,226.7	1,285,199.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	215,571.1	215,571.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	950,267.9	896,778.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	260,387.7	172,849.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	140,712.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	388,591.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	90	48
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44	23

дундговь аймгийн Адаацаг сумын засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	24	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,221.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,221.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,267.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,352.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,950.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,464.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,954.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,954.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	82,184.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,184.4
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-2,037.3
9	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,037.3
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо “Төр иргэний оролцоог ил тод нээлттэй болгож иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд Боловсрол, соёл, эрүүл мэндийн салбаруудын төсвийн шинэчлэлтэй холбоотой сумын 4 төсөвт байгууллага нь тусгай шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжиж, улсын болон орон нутгийн төсвөөс тус тус санхүүжилт авдаг болон өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, дотоод аудитыг ТЕЗ-ийн харьяа Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, орон нутгийн төсвөөс санхүүждэг байсан Соёлын төвүүд харьяалагдах яамдаасаа санхүүжилтээ авч, санхүүгийн тайлангаас яамдад нэгтгүүлдэг болсон. Нэгтгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 2022 оны байгууллагуудын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэн өгсөн байна. Дээрх байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

Тайлант хугацаанд Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.4.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,861,595.6 мянган төгрөгөөр буюу 55.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт №1.	/мянган төгрөг/		
	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,434,089.9	853,360.6	-580,729.4
Мөнгөн хөрөнгө	403,205.6	468,191.8	64,986.2
Авлага	472,159.0	225,007.2	-247,151.8
Бараа материал	558,725.4	160,161.5	-398,563.8
Үндсэн хөрөнгө	3,758,303.8	1,477,437.6	-2,280,866.2
Нийт хөрөнгийн дүн	5,192,393.8	2,330,798.2	-2,861,595.6
Нийт өр төлбөр	21,193.5	5,150.0	-16,043.5
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,171,200.3	2,325,648.2	-2,845,552.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,192,393.8	2,330,798.2	-2,861,595.6

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 64,986.2 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн тендер шалгаруулалт явагдаагүй 143,879.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, Байгаль хамгаалах санд 95,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулалт хийгдээгүй үлдэгдэл 64,991.0 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт зэргээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 247,151.8 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн 218,087.7 мянган төгрөгийн ЭМД-ын сангаас авах цар тахлын дутуу санхүүжилт орж ирсэн Сум хөгжүүлэх сангийн авлага 45,650.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, цэвэр хөрөнгийн дансууд нь боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын төсвийн шинэчлэлтэй холбоотой сургуулийн 1,255,333.5 мянган төгрөг, цэцэрлэгийн 389,430.0 мянган төгрөг, эмнэлгийн 952,273.1 мянган төгрөг, Соёлын төвийн 119,526.4 мянган төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлснээр буурсан байна.

3.4.2 Орлого бүрдүүлэлт

Дундговь аймгийн Адаацаг сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 15 дугаар тогтоолоор Адаацаг сум тайлант онд 241,930.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 267,918.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 110.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Цалин түүнтэй адилтгах орлого	95,300.0	119,283.9	23,983.9	125.2
Хувь хүний орлогын албан татвар	24,000.0	25,736.1	1,736.1	107.2
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,000.0	4,232.3	1,232.3	141.1
Бууны албан татвар	1,750.0	1,444.0	(306.0)	82.5
Улсын тэмдэгтийн хураамж	2,280.0	1,135.5	(1,144.5)	49.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	400.0	150.0	(250.0)	37.5
Газрын төлбөр	5,800.0	7,689.0	1,889.0	132.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,300.0	12,298.9	2,998.9	132.2
Малын тоо толгойн албан татвар	60,000.0	68,294.1	8,294.1	113.8
Дүн	201,830.0	240,263.8	38,433.8	119.0
Татварын бус орлого				
Хадгаламжийн хүүгийн орлого	26,300.0	18,200.8	(8,099.2)	69.2
Торгуулийн орлого	12,600.0	8,783.4	(3,816.6)	69.7
Бусад орлого	1,200.0	700.0	(500.0)	58.3
Дүн	40,100.0	27,684.2	(12,415.8)	69.0
Нийт дүн	241,930.0	267,948.0	26,018.0	110.8

Эх сурвалж: Адаацаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дараах орлогууд материаллаг дүнгээр давж биелсэн байна. Үүнд:

- Цалин түүнтэй адилтгах орлогын албан татварын орлого 23,983.9 мянган төгрөгөөр давсан нь 2022 оны эхэнд цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Хувь хүний орлогын албан татварын орлого 1,736.1 мянган төгрөгөөр давсан нь ноосны урамшуулал орж ирсэнтэй холбоотой.
- Үл хөдлөх эд хөрөнгийн орлогын албан татварын орлого 1,232.3 мянган төгрөгөөр давсан нь суманд шинээр үл хөдлөх хөрөнгүүд баригдан, тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Газрын төлбөр 1,889.0 мянган төгрөгөөр давсан нь суманд үйл ажиллагаа эрхлэх ААНБ-ын газрын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Малын тоо толгойн албан татвар 8,294.1 мянган төгрөгөөр давсан нь өмнөх жилийн дутуу татвар орж ирсэнтэй холбоотой.

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна. Үүнд:

- Бууны албан татварын орлого 306.0 мянган төгрөгөөр тасарсан нь сумд бүртгэлтэй бууны тоогоор төлөвлөгөөг батлалгүй өндөр тавьж өгсөнтэй холбоотойгоор төлөвлөгөө тасарсан байна.
- Улсын тэмдэгтийн хураамж 1,144.5 мянган төгрөгөөр тасарсан нь суманд ЗДТГ-ын дарга 2022 онд байхгүй байсан учир нотариатын орлого ороогүйтэй холбоотой байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 250.0 мянган төгрөгөөр тасарсан нь 2022 онд айл өрх албан байгууллагууд элс хайрга ашиглаагүйтэй холбоотой байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 8,099.2 мянган төгрөгөөр тасарсан нь ковидтой холбоотой оны эхэнд хүүг зогсоосон байсан мөн хадгаламжийн хүүгийн орлого буурсантай холбоотой тасарсан байна.
- Торгуулийн орлого 3,816.6 мянган төгрөгөөр тасарсан нь зөрчил буурсантай холбоотой тасарсан байна.
- Бусад орлого 500.0 тасарсан нь тухайлан нэр заасан орлого байхгүйтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Адаацаг сумын ИТХ-ын 2021 оны 11 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,477,803.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,477,803.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Адаацаг сумын ИТХ-ын 2022 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 1 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 51,576.3 мянган төгрөгөөр бууруулан, 1,426,226.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус онд улсын төсвийн байгууллагуудын үйлчилгээний ажилчдын цалинг орон нутгийн санхүүжилт дээр баталсан байсныг хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор улсын төсөвт шилжүүлэн санхүүжилтийг хасан баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1,426,226.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 954,452.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 373,447.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 98,327.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 215,571.1 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 950,267.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 260,387.7 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Орон нутгийн хөгжлийн сангаас 215,571.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 896,778.0 мянган төгрөг, 172,849.8 үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос нийт 1,285,199.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 122,629.9 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 62,629.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, туслах үйл ажиллагааны орлого 50,219.9 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 27,980.1 мянган төгрөгөөр тасарч, нийт төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 34,649.8 мянган төгрөгөөр давсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого тасарсан шалтгаан нь байгаль, цаг агаар байдлаас шалтгаалан өвсний татан авалт төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүй, төсөвт байгууллагууд Ахмадын санд орлого төвлөрүүлээгүйгээс туслах үйл ажиллагааны орлого тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,023,388.5 мянган төгрөг буюу 71.5 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний бусад зардалд 757,088.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 173,529.1 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Орон нутгийн санхүүжилтээс дутуу зарцуулсан 53,489.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд хандив тусламжаар 50,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 20,217.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11,967.1 мянган төгрөг, нийт 82,184.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Хангамж бараа материалын зардалд 2,352.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 1,950.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 18,464.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18,500.0 мянган төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардалд нийт 41,267.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 40,916.6 мянган төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 2,037.3 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 01-ний өдрийн 01/39 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 2,330,798.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 23,307.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,315.6 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланг түүвэрлэн шалгахад тус сумын Засаг даргын Тамгын газар нь төсвөөс төсвийн шууд захирагчид хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвөөс 1,670.9 мянган төгрөгийн урамшуулал олгосныг буцаан төлүүлэхээр болж, Дундговь аймгийн 80 жилийн үйл ажиллагаанд зориулан, үндсэн чиг үүрэгт хамааралгүй зардалд 20,000.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна. Сумын ИТХ нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт бичиг хэрэг, шатахууны зардлыг олгохдоо бүрдэл дутуу анхан шатны баримтыг үндэслэн 8,740.0 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага өгсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга нь 2022 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

Харин шилэн дансанд байршуулсан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй сумын Засаг даргын Тамгын газарт хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь сумын Засаг даргын Тамгын газрын хувьд шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Адаацаг сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй. Харин тус сумын Засаг даргын Тамгын газар, Орон нутгийн хөгжлийн сан, Байгаль хамгаалах сан, Мал хамгаалах сангуудад хийсэн завсрын аудитаар нийт 201,812.5 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрч, 6,888.8 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулсан, 194,923.6 мянган төгрөгийн 3 зөрчилд хугацаатай албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Жилийн эцсийн аудитаар алдаа зөрчлийн хэрэгжилт 95 хувьтай байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 1,555.2 мянган төгрөгийн устгах бичилтийг дутуу хийснийг залруулж, санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 7,223.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 25,830.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага хүргүүлсэн байна. Хэрэгжээгүй 5,000.0 мянган төгрөгийн Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрүүлсэн төлбөрийн актыг 2022 оны 12 дугаар сарын 27-нд хуулийн байгууллагад шилжүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	7,223.5	2	2,223.5	1	5,000.0	30.8
Албан шаардлага	11	25,830.6	11	25,830.6			100
Зөвлөмж							
Нийт	13	33,054.1	13	28,054.1	1	5,000.0	84.8

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын бараа материалын зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 374,159.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 148,824.6 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 1,670.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 223,663.7 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 60.2 хувийг залруулагдаагүй, 39.8 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дундговь аймгийн Алацаг сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Засаг даргын Тамгын газар	3	21,670.9	1	1,670.9	2	20,000.0			
Орон нутгийн хөгжлийн сан	3	170,493.4			2	170,493.4	1		
Дүн	6	192,164.3	1	1,670.9	4	190,493.4	1		
Нийт дүн	7	192,164.3	1	1,670.9	5	190,493.4	1	-	-